



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.САРАНГЭРЭЛ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠗.᠒᠔ № 74
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төв ЭМДС-аас өмнөх оны авлагын үлдэгдэл 50.1 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид хүсэлт хүргүүлж, эх үүсвэр нь дутагдаж байгаа зардалд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>120,368,118.39</u>	<u>144,124,257.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,587,196.46	83,844,824.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,587,196.46	83,844,824.16
3121	Төгрөг	7,587,196.46	83,844,824.16
31211	Төрийн сангийн харилцах	7,587,196.46	83,844,824.16
33	АВЛАГА	50,112,800.00	00.00
335	Бусад авлага	50,112,800.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	50,112,800.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	62,668,121.93	60,279,433.00
351	Түүхий эд материал	20,204,934.73	25,317,969.00
35110	Тусгай зориулалттай материал	414,700.00	385,000.00
35130	Эм боох материал	19,790,234.73	24,932,969.00
354	Хангамжийн материал	34,983,187.20	28,981,464.00
35410	Бичиг хэргийн материал	667,100.00	1,146,900.00
35420	Аж ахуйн материал	13,567,460.00	18,166,930.00
35430	Сэлбэг хэрэгсэл	70,000.00	6,500,000.00
35440	Түлш, шатах тослох материал	712,500.00	858,000.00
35460	Хүнсний материал	807,520.00	1,959,634.00
35470	Бусад хангамжийн материал	19,158,607.20	350,000.00
35600	Мал амьтад	7,480,000.00	5,980,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>161,296,063.00</u>	<u>164,774,361.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	161,296,063.00	164,774,361.21
392	Биет хөрөнгө	159,378,063.00	160,986,048.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	120,138,170.00	120,138,170.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,200,465.44	-44,874,947.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,587,500.00	-14,917,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,697,887.65	69,512,426.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,130,301.57	-15,336,161.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,186,267.30	16,266,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,280,615.37	-6,746,808.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,211,000.00	12,211,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,156,379.57	-6,766,929.61
393	Биет бус хөрөнгө	1,918,000.00	3,788,312.50
39301	Програм хангамж	1,070,000.00	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,070,000.00	-124,687.50
39303	Бусад биет бус хөрөнгө	1,918,000.00	1,918,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>281,664,181.39</u>	<u>308,898,618.37</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>281,664,181.39</u>	<u>308,898,618.37</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	281,664,181.39	308,898,618.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,289,096.51	162,289,096.51
51101	Өмч: - төрийн	162,289,096.51	162,289,096.51
512	Хуримтлагдсан үр дүн	74,240,002.51	101,474,439.49
51210	Өмнөх үеийн үр дүн	74,240,002.51	74,240,002.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	27,234,436.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,135,082.37	45,135,082.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>281,664,181.39</u>	<u>308,898,618.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	668,495,791.95	534,259,422.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,232,245.95	43,773,732.00
120	Нийтлэг татварын бус орлого	91,232,245.95	43,773,732.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,232,245.95	43,773,732.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	797,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	91,232,245.95	42,976,632.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	268,465,446.00	490,485,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	34,382,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	34,382,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,798,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,220,306.00	36,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,830,306.00	36,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	390,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,770,200.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,770,200.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	63,474,940.00	456,066,990.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	63,474,940.00	456,066,990.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	562,557,615.89	504,160,069.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,557,615.89	504,160,069.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,885,419.60	477,276,861.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,397,505.24	245,857,123.90
210101	Үндсэн цалин	136,151,156.54	162,309,739.04
210102	Нэмэгдэл	83,160,728.70	64,621,951.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,320,550.99	3,188,000.00
210104	Урамшуулал	13,765,069.01	15,737,433.60

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,818,398.30	27,492,602.60
210201	Тэтгэврийн даатгал	21,591,978.82	18,105,138.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,386,083.05	2,360,645.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,508.97	1,881,736.52
210204	Ажилгүйдлийн даатгал	426,550.02	467,780.11
210205	Эрүүл мэндийн даатгал	4,581,277.44	4,677,301.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,328,243.71	9,255,598.92
210301	Гэрэл, цахилгаан	4,671,491.37	3,408,034.92
210302	Түлш, халаалт	15,000,152.34	5,272,164.00
210303	Цэвэр, бохир ус	656,600.00	575,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,949,092.00	30,520,730.00
210401	Бичиг хэрэг	1,666,390.00	2,179,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,579,600.00	18,305,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,812,040.00	1,723,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,953,800.00	1,701,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,414,400.00	2,159,480.00
210408	Бараа материал акталсны зардал	5,522,862.00	4,451,450.00
2105	Нормативт зардал	143,330,123.20	117,451,053.73
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,461,395.20	107,736,367.73
210502	Хоол, хүнс	12,853,728.00	9,714,686.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,521,200.00	9,298,600.00
210604	Урсгал засвар	9,521,200.00	9,298,600.00
2107	Томилолт, зочны зардал	397,000.00	2,558,000.00
210702	Дотоод албан томилолт	397,000.00	2,558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,523,351.00	2,553,165.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,523,351.00	2,553,165.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,620,506.15	32,289,987.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,372,930.00	8,540,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,247,576.15	23,749,887.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,672,196.29	26,883,208.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,798,500.00	7,349,607.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,798,500.00	7,349,607.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,873,696.29	19,533,601.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,873,696.29	19,533,601.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	105,938,176.06	30,099,352.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,864,915.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,864,915.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,864,915.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	105,938,176.06	27,234,436.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	527,150,746.00	541,395,590.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	797,100.00
78	Нийтлэг татварын бус орлого	-	797,100.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	797,100.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	797,100.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,150,746.00	540,598,490.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	-	34,382,700.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	34,382,700.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,798,100.00	-
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,220,306.00	36,000.00
122	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	8,000,000.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	149,830,306.00	36,000.00
126	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	390,000.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,770,200.00	-
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,770,200.00	-
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,362,140.00	506,179,790.00
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,362,140.00	506,179,790.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	515,119,549.54	445,218,262.30
148	УРСГАЛ ЗАРДАЛ	515,119,549.54	445,218,262.30
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,447,353.25	418,335,054.22
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	236,397,505.24	245,857,123.90
151	Үндсэн цалин	136,151,156.54	162,309,739.04
152	Нэмэгдэл	83,160,728.70	64,621,951.26
153	Унаа хоолны хөнгөлөлт	3,320,550.99	3,188,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	13,765,069.01	15,737,433.60
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	30,818,398.30	27,492,602.60
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,591,978.82	18,105,138.90
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,386,083.05	2,360,645.65
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,832,508.97	1,881,736.52
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	426,550.02	467,780.11
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,581,277.44	4,677,301.42
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	18,168,203.71	9,401,098.92
165	Гэрэл цахилгааны зардал	4,671,491.37	3,408,034.92
166	Түлш, халаалтын зардал	12,840,112.34	5,417,664.00
167	Цэвэр, бохир усны зардал	656,600.00	575,400.00
170	Хангамж, бараа материалын зардал	33,679,790.00	28,472,500.00
171	Бичиг хэрэг	1,592,500.00	3,058,800.00
172	Тээвэр, шатахуун	20,579,600.00	18,305,700.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,812,040.00	1,723,800.00

175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,584,300.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,695,650.00	3,799,900.00
181	Нормативт зардал	123,346,055.00	79,888,363.80
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,932,105.00	63,305,563.80
183	Хоол, хүнс	8,213,950.00	10,082,800.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	6,500,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	10,109,200.00	16,362,100.00
186	Багаж техник хэрэгсэл	50,000.00	-
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	-	633,500.00
189	Урсгал засвар	10,059,200.00	15,728,600.00
190	Томилолт, зочны зардал	397,000.00	2,558,000.00
192	Дотоод албан томилолт	397,000.00	2,558,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,537,351.00	2,553,165.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	15,537,351.00	2,553,165.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,993,850.00	5,750,100.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	1,993,850.00	5,750,100.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,672,196.29	26,883,208.08
225	Бусад урсгал шилжүүлэг	25,798,500.00	7,349,607.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	25,798,500.00	7,349,607.00
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,873,696.29	19,533,601.08
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,873,696.29	19,533,601.08
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,031,196.46	96,177,327.70
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,444,000.00	19,919,700.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,444,000.00	19,919,700.00
263	Дотоод эх үүсвэрээр	4,444,000.00	19,919,700.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,444,000.00	19,919,700.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,444,000.00)	(19,919,700.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,587,196.46	76,257,627.70
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	7,587,196.46
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,587,196.46	83,844,824.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-31,698,173.55	00.00	175,726,005.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	-31,698,173.55	00.00	175,726,005.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	105,938,176.06	00.00	105,938,176.06
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	74,240,002.51	00.00	281,664,181.39
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	74,240,002.51	00.00	281,664,181.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	74,240,002.51	00.00	281,664,181.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	27,234,436.98	00.00	27,234,436.98
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,289,096.51	45,135,082.37	101,474,439.49	00.00	308,898,618.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	574,245,700.00	445,604,361.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,245,700.00	445,604,361.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,245,700.00	438,254,754.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,782,500.00	245,857,123.90
210101	Үндсэн цалин	239,333,000.00	162,309,739.04
210102	Нэмэгдэл	48,147,600.00	64,621,951.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.00	3,188,000.00
210104	Урамшуулал	6,513,900.00	15,737,433.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,497,800.00	27,492,602.60
210201	Тэтгэврийн даатгал	24,138,500.00	18,105,138.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,800.00	2,360,645.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,271,800.00	1,881,736.52
210204	Ажилгүйдлийн даатгал	568,000.00	467,780.11
210205	Эрүүл мэндийн даатгал	5,679,700.00	4,677,301.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,100,000.00	9,401,098.92
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	3,408,034.92
210302	Түлш, халаалт	25,000,000.00	5,417,664.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	575,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,433,500.00	28,472,500.00
210401	Бичиг хэрэг	6,369,700.00	3,058,800.00
210402	Тээвэр, шатахуун	18,305,700.00	18,305,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,850,000.00	1,723,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,833,100.00	1,584,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,075,000.00	3,799,900.00
2105	Нормативт зардал	90,429,100.00	79,888,363.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,517,400.00	63,305,563.80
210502	Хоол, хүнс	18,411,700.00	10,082,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	6,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,243,000.00	31,786,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,124,900.00	14,124,700.00
210602	Тавилга	4,000,000.00	1,300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,342,500.00	633,500.00
210604	Урсгал засвар	19,775,600.00	15,728,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,600,600.00	2,558,000.00
210702	Дотоод албан томилолт	2,600,600.00	2,558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,409,100.00	7,048,165.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,114,100.00	2,553,165.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,295,000.00	4,495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5750100.00	5750100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,750,100.00	5,750,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13000000.00	7349607.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,000,000.00	7,349,607.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	7,349,607.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	574,245,700.00	521,861,988.92
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,395,000.00	14,849,098.92
131001	Улсын төсвөөс санхүүжих	42,395,000.00	14,849,098.92
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	531,053,600.00	506,179,790.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	531,053,600.00	506,179,790.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	797,100.00	797,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	797,100.00	797,100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	7,587,196.46
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	83,844,824.16
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төв “Үйлчлэх хүрээний хүн амд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэвшилтэд технологид тулгуурлан тэгш хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулалгүй үзүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,234.4 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,587.20	83,844.80	76,257.60
Авлага	50,112.80	-	-50,112.80
Бараа материал	62,668.10	60,279.40	-2,388.70
Үндсэн хөрөнгө	161,296.10	164,774.40	3,478.30
Нийт хөрөнгө	281,664.20	308,898.60	27,234.40
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	281,664.20	308,898.60	27,234.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	281,664.20	308,898.60	27,234.40

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 76,257.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Авлагын данс 50,112.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 164,774.4 мянган төгрөг болж 3,478.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 19,919.7 мянга, үнэ төлбөргүй 3,988.4 мянга, шилжүүлж авсан 6,185.0 мянга нийт 30,093.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 37,798.4 мянган төгрөг хөрөнгийг акталж, 6,474.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 27,234.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох нормативт зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд ЭМДС-аас санхүүжилт 531,850.7 мянга, орон нутгийн санхүүжилт 42,395.0 мянга нийт 574,245.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 445,604.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр харилцах дансны эхний үлдэгдэл 7,587.2 мянга, ЭМД-ийн сангаас 506,179.8 мянга, орон нутгийн санхүүжилт 34,382.7 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 797.1 мянга, дээд шатны төсөв захирагчаас 36.0 мянга нийт 541,395.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 19,533.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 83,844.8 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 445,604.3 мянган төгрөг буюу 77 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	37,100.0	10,354.1	26,745.9	28%
2	80302-нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	193,884.1	162,325.3	31,558.8	84%
3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж	274,713.0	211,350.3	63,362.7	77%
4	83201-ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ	5,295.0	4,495.0	800.0	85%
5	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	63,253.6	57,079.6	6,174.0	90%
НИЙТ		574,245.7	445,604.3	128,641.4	

Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 94,921.5 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Наран сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 11,251.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,875.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 11,072.0 мянга, хангамж, бараа материалын зардлууд 7,428.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээний 13.0 сая, урсгал санхүүжилтийн 17 гүйлгээний 494.5 сая төгрөгийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5³ заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр бүрээр www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Наран сумын эрүүл мэндийн төвд завсрын аудит хийгээгүй.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

³ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 зөрчил⁴ илэрснээс дахин давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал									
/мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<i>www.shilendans.gov.mn</i> цахим хуудсанд мэдээлэл оруулсан дутуу	1	-	-	-	1	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	1	-	-	-	-

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.